| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 | 0.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.00 | 274,881.00 | 25,119.00 | 91.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 108000000.00 | 101625810.00 | 6,374,190.00 | 94.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний | 108,000,000.00 | 101,625,810.00 | 6,374,190.00 | 94.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бусад зардал | | | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1500000.00 | 1500000.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,109,161,500.00 | 1,034,013,074.36 | 75,148,425.64 | 93.2 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,108,161,500.00 | 1,032,574,954.36 | 75,586,545.64 | 93.2 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,108,161,500.00 | 1,032,574,954.36 | 75,586,545.64 | 93.2 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 1,438,120.00 | -438,120.00 | 143.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,438,120.00 | -438,120.00 | 143.8 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 13 | 13 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | 7 | 7 | 0.00 | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7 | 7 | 0.00 | 100.0 |

**2.5 Нэмэлт дансны тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21,559,434.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,559,434.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,273,108.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3273108.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,273,108.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16286326.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,286,326.50 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,286,326.50 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 21559434.50 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,559,434.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,559,434.50 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хэрэгжүүлэн ажилладаг сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого шийдвэрийг боловсруулах,



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ... САЛ ДУГНЭЛТ

хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг)" хийх үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах" чиг үүрэгтэй ажилладаг.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,854,829.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 563,893.4 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 17,790.4 | 13,960.8 | 3,829.6 |
| Бараа материал | 163,874.7 | 186,809.1 | (22,934.5) |
| Үндсэн хөрөнгө | 2,978,016.9 | 3,578,919.4 | (600,902.5) |
| Хуримтлагдсан элэгдэл | (868,745.5) | (924,859.5) | 56,114.1 |
| **Нийт хөрөнгө** | **2,290,936.5** | **2,854,829.9** | **(563,893.4)** |
| Өр төлбөр | 3,115.0 | 3,685.2 | (570.2) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,287,821.5 | 2,851,144.7 | (563,323.2) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,290,936.5** | **2,854,829.9** | **(563,893.4)** |

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 13,960.8 мянган төгрөг болж өмнөх оноос 3,829.6 мянган төгрөгөөр буурсан байгаа нь ажиллагсадтай холбоотой авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 186,809.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хөрөнгөөр 134,225.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сумын ОНХС-аас 36,998.0 мянган төгрөгийн өвс тэжээл, бусад эх үүсвэрээс 18,208.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 166,498.2 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,685.2 мянган төгрөг болж өмнөх оноос 570.2 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой өглөг өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,578,919.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хөрөнгөөр 126,007.6 мянга төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймаг сумын ОНХС-аас 440,074.1 мянга, Шинэ хөдөө төсөл хөтөлбөрөөс 149,150.0 мянга, аймгийн ЗДТГ-аас 20,340.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2/13 дугаар тогтоолоор 111,679.6 мянга, аймгийн Засаг даргын 2023 оны А/147 дугаар захирамжаар 19,990.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,851,144.7 мянган төгрөг болж 563,323.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 563,323.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төслийг аудитын газарт ирүүлээгүй шилэн дансанд байршуулаагүй байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,108,161.5 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төсөв батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,109,161.5 мянган төгрөг батлагдсанаас 1,034,013.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,034,013.1 мянган төгрөг буюу 93 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 45,599.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь голлох нөлөө үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 үндсэн үйл ажиллагаа зардал | 645,466.3 | 599,867.2 | 45,599.1 | 93% |
| 2 | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 164,019.9 | 155,993.9 | 8,026.0 | 95% |
| 3 | 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж | 1,000.0 | 1,000.0 | 0.0 | 100% |
| 4 | 81102 орон нутгийн нөөц хөрөнгө | 108,000.0 | 101,625.8 | 6,374.2 | 94% |
| 5 | 81701 байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал | 151,267.3 | 36,131.1 | 15,136.3 | 90% |
| 6 | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдолыг бууруулах | 39,408.0 | 39,395.1 | 12.9 | 100% |
| | Нийт дүн | 1,109,161.5 | 1,034,013.1 | 75,148.4 | 93% |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 45,599.1 мянга буюу 7 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 8,026.0 мянга буюу 5 хувь, орон нутгийн нөөц хөрөнгөөс 6,374.2 мянга буюу 6 хувь, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 15,136.3 мянга буюу 10 хувь, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зардлаас 12.9 мянга нийт 75,148.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 4 төрлийн 23,559.4 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* /мян.төг/

| № | ЭХ ҮҮСВЭРИЙН | | Зарцуулалт | | | НИЙТ | ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрөл | Дүн | 6 сарын санхүүжилт | мал тооллогын зардал | хамтарсан багийн санхүүжилт | | |
| 1 | 6 сарын тэтгэмжийн санхүүжилт | 16,286.3 | 16,286.3 | - | - | 16,286.3 | - |
| 2 | Мал тооллого санхүүжилт | 3,273.1 | | 3,273.1 | | 3,273.1 | - |
| 3 | Хамтарсан багийн санхүүжилт | 2,000.0 | | | 2,000.0 | 2,000.0 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Барьцаа төлбөр | 2,000.0 | | | | - | 2,000.0 |
| | Нийт дүн | 23,559.4 | 16,286.3 | 3,273.1 | 2,000.0 | 21,559.4 | 2,000.0 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орлогыг 21,599.4 мянган төгрөгийн зориулалтын дагуу зарцуулсан ба барьцаа төлбөрийн 2,000.0 мянган төгрөгийг сумын ОНХС-ын дансанд төвлөрүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2025 оны 1 сарын 25-д ирүүлсэн.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг М.Чинбат, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Түмэнболд, Н.Амартүвшин нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны анх батлагдсан төсвийн нийт зардлын 617,071.0 мянган төгрөгөөс тооцоход 6,170.7 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 4,011.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,078,545.0 мянган төгрөгийн 42 гүйлгээ байршуулахаас 70,848.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 261,038.6 мянган төгрөгийн 15 гүйлгээ гүйлгээ байршуулахаас 27,584.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ байршуулаагүй байна.,

Мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 49,484.3 мянган төгрөгийн 32 мэдээллийг байршуулсан ба халаалтын гэрээ, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой гэрээнүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 60,852.2 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 59,852.2 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын Fas системд оруулж хэрэгжилтийг 100 хувь тооцсон байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | 100 |
| Албан шаардлага | 3 | 59,852.2 | 3 | 59,852.2 | 100 |
| **Нийт дүн** | 4 | 60,852.2 | 4 | 60,852.2 | 100 |

Эх сурвалж: 2024 оны аудитын тайлангаас

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,300.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант хугацаанд ажиллагсдаас 2,932.6 мянган төгрөгийг ҮЭ суутгаж 2,926.7 мянган төгрөгийг төлж 6.0 мянган төгрөгийн өглөгтэй байхад цалингийн зардал руу хааж бичсэн байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", заалтыг зөрчсөн тул санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулав.

2. Тайлант онд хүүхэд асарсны чөлөөтэй байгаа албан хаагчдын ажил олгогчоос төлөх НДШ-ийн 1,597.2 мянган төгрөгийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.6 дахь "Бүх зардал" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Тайлант оны эхэнд Нийгмийн даатгалын шимтгэлийн 825.8 мянган төгрөгийн авлагатай байсан ба тайлангаар 144,776.7 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг үүсэж 147,146.8 мянган төгрөгийг төлж оны эцэст 3,697.0 мянган төгрөг илүү төлсөн байхад тайланд авлагаар тусгаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна

4. Тайлант онд 55,206.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй бараа материал шилжүүлэн авсан байхад нягтлан бодогч 915.0 мянган төгрөгөөр бууруулан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5 дахь "Бүх орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 104,452.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 1,628.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 102,824.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**5.1 Төлбөрийн акт**

1. Тус байгууллагын 2 албан хаагчид 16,286.3 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгосон ба ХАОАТ-ыг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Суутган тооцоогүй ХАОАТ-ын 1,628.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.1 Албан шаардлага**

1. Гэрэл цахилгааны зардлаас 2024 оны 12 сарын 26-ны өдөр "Далай банди" ХХК руу 1,540.0 мянган төгрөгийг шилжүүлж гэрлийн утас авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Урсгал зардлын тайлбар"-ын 213101 "Гэрээ болон хэмжих тоолуурын заалтын дагуу байгууллагын хэрэгцээнд ашигласан цахилгаан эрчим хүчний төлбөр, өөрийн эх үүсвэрээр цахилгааны эрчим хангахад гарсан зардлыг хамааруулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Байгал хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас идэвхтэн байгаль хамгаалагч 3 иргэний урамшууллаас 2,851.2 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл авч мөнгийг шилжүүлсэн боловч Нийгмийн даатгалд мэдээлээгүй байна

Энэ нь Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн 25 дүгээр зүйлийн 25.1 дэх "Ажил олгогч тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны дотор цахим, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулж, харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, эсхүл нийтээр амрах баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр тайлагнана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нэр бүхий албан хаагчдын Нийгмийн даатгалын цахим сайтад мэдээлж өмнөх оны авлагаас суутган тооцох албан шаардлагыг хүргүүлэв.

3. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,078,545.0 мянган төгрөгийн 42 гүйлгээ байршуулахаас 70,848.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 261,038.6 мянган төгрөгийн 15 гүйлгээ гүйлгээ байршуулахаас 27,584.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, халаалт, бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээнүүдийг байршуулаагүй байна.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------oOo-----------

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус байгууллагын 2 албан хаагчид 16,286.3 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгосон ба ХАОАТ-ыг суутгаагүй байна.. | 1 | 1,628.6 | 1 | 1,628.6 | | | | |
| Гэрэл цахилгааны зардлаас 2024 оны 12 сарын 26-ны өдөр "Далай банди" ХХК руу 1,540.0 мянган төгрөгийг шилжүүлж гэрлийн утас авсан. | 1 | 1,540.0 | | | 1 | 1,540.0 | | |
| Байгал хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас идэвхтэн байгаль хамгаалагч 3 иргэний урамшууллаас 2,851.2 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл авч мөнгийг шилжүүлсэн боловч Нийгмийн даатгалд мэдээлээгүй байна | 1 | 2,851.2 | | | 1 | 2,851.2 | | |
| **Дүн** | **3** | **6,019.8** | **1** | **1,628.6** | **2** | **4,391.2** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 70,848.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 27,584.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, халаалт, бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээнүүдийг байршуулаагүй байна | 1 | 98,432.8 | | | 1 | 98,432.8 | | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 98,432.8 | | | 1 | 98,432.8 | | |

----------oOo-----------